



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 06 дугаар сарын 11 өдөр Дугаар 39

Хэрлэн сум

XXXIX ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 39 дүгээр хурал 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Хүчтэй салхины улмаас Хэрлэн сумын 1 дүгээр багийн 28 дугаар байрны дээвэр хууларсантай холбогдуулан барилга ашиглалтын болон хохиролын үнэлгээ тогтоох мэргэжлийн албан хаагч нарыг томилж ажиллуулсан талаар танилцуулах,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Х.Бат-Эрдэнэ

2. Хэрлэн сумын 6, 7 дугаар багийн төмөр дээвэртэй 8, 10, 46 дугаар байруудын дээврийн аюулгүй байдалд хяналт шалгалтыг зохион байгуулсан талаар танилцуулах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Д.Мөнхтуяа

3. Хилийн Баянхошуу боомтод коронавируст халдварын эрсдлийн үнэлгээ хийсэн тухай танилцуулах,

*Онцгой байдлын газрын орлогч,
УСТ-ийн дарга, дэд хурандаа Д.Баттулга*

4. Удирдамжийн дагуу "Ухаа арал" амралтын газарт хяналт, шалгалт хийсэн тухай танилцуулах.

Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын

гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.1.Хэрлэн сумын 1 дүгээр багийн 28 дугаар байрны дээвэр хууларсантай холбогдуулан эд хөрөнгийн үнэлгээний компаниар хохирлын бодит үнэлгээ хийлгэхийг,

Хоёр. АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал,

Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Дамдинбазар,

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга, Онцгой комиссын гишүүн М.Алтаннавч нарт:

2.1.Хүчтэй салхины улмаас Хэрлэн сумын 1 дүгээр багийн 28 дугаар байрны дээвэр хууларсан талаарх шалтгаан нөхцлийг тодорхойлж, мэргэжлийн хяналтын байгууллагын эрх бүхий хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахыг,

2.2.Барилгын дээврийн засварын хөрөнгө шийдвэрлэх хүртэл хэрхэн хамгаалах талаар зохицуулалт хийх, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар судалгаа гарган танилцуулж, шийдвэр гаргуулахыг,

Гурав. АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д

3.1.Хэрлэн сумын 1 дүгээр багийн 28 дугаар байрны дээвэр хууларсантай холбоотой хууль, эрх зүйн талаас хохирлын нөхөн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх талаарх саналыг аймгийн Онцгой комиссын 40 дүгээр хуралдаанд танилцуулахыг,

Дөрөв.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

4.1.Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг баримтлан ажиллах талаар сумын Засаг дарга нарт албан бичиг боловсруулж танилцуулахыг,

Тав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

5.1.Орон сууцны 8, 10, 46 дугаар байруудын дээврийн аюулгүй байдалд хийсэн хяналт шалгалтын талаарх дүгнэлт гарсны дараа бэхэлгээ хийх, цаашид барилгын дээврийг хавтгай дээвэртэй болгох ажлыг зохион байгуулахыг,

Зургаа. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

6.1.Хэрлэн сумын бүх СӨХ-ны дарга нарыг мэргэжлийн байгууллагатай хамтран орон сууцны барилгуудын орц, дээвэр, бэхэлгээ, бусад хэсгүүдэд үзлэг,

шалгалтыг зохион байгуулах талаар үүрэг даалгаврыг албан бичгээр өгч, аймгийн Онцгой комиссын 40 дүгээр хуралдаанд танилцуулахыг,

Долоо. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д

7.1.Баянхошуу хилийн боомтод хийсэн гамшгийн эрсдэлийн үнэлгээний дүн, зөвлөмжийг яаралтай ирүүлэх тухай Онцгой байдлын ерөнхий газарт албан бичиг хүргүүлж, хувийг Петрочайна Дачин Тамсаг ХХК-д хүргүүлэхийг,

Найм. Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий нарт:


8.1."Ухаа арал" амралтын газарт хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн пүрэв гарагт дахин ажиллуулах талаар шийдвэр гаргуулахыг,


Ес. "Дорнод Нийтийн аж ахуй" ОНӨААТҮГ-ын захирал, Онцгой комиссын гишүүн Г.Баярсайхан-д

9.1.Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сайжруулж, аймгийн Онцгой комиссын 40 дүгээр хуралдаанд танилцуулахыг,

Арав. Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

10.1.БНХАУ-ын хилийн боомтын гаалийн хяналтын талбайд үлдсэн Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн судалгааг Гаалийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хил хамгаалах байгууллагатай хамтран гаргаж, нэгтгэлийг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч даргад танилцуулж, Улсын онцгой комиссын Шуурхай штабт 2020 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн дотор хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА